

НДЕГ-ЫН ДАРГЫН “АЖЛЫН ХАРИУЦЛАГА, САХИЛГА, ДЭГ ЖУРМЫГ САЙЖРУУЛАХ,
АЖИЛ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ” 01 АЛБАН ДААЛГАВРЫН ХҮРЭЭНД ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Биелэлт
НЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, УДИРДЛАГА БОЛОН АЛБАН ХААГЧДЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:		
1.1	Нийгмийн даатгалын байгууллагад үйлчилгээ авахаар хандсан иргэн, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч (үйлчлүүлэгч) нарт үйлчилгээг мэргэжлийн түвшинд бүрэн гүйцэд, чанартай, шуурхай, хүнд сурталгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх, үйлчилгээний талаар ойлгомжтой тодорхой танилцуулах, зөвлөн туслах, үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэхгүй байхад анхаарах;	Иргэд даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр тэтгэмж авагч нарт чанартай, шуурхай, хүнд сурталгүй үйлчлэх чиглэлээр анхааран ажиллаж тус хэлтэст хандан ирүүлсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэн ажилласан. Мөн зөвлөгөө, үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, чирэгдэлгүй үйлчилж ажилласан.
1.2	Удирдлагууд мэргэжлийн мэдлэг, сахилга бат, ёс зүйгээр манлайлж ажиллах, ажлын байран дээр болон албан томилолтоор албан үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйн болон харилцааны зөрчил гаргасан, хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгоор шан харамж авсан, томилолтын байр, хоолны зардлыг бусдаар төлүүлсэн, зүй бус үйлдэл гаргасан албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох	Нийгмийн даатгалын ерөнхий газраас Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд нэр бүхий гурван ажилтанд алдаа, зөрчил гаргасан болон ажилтан, албан хаагчтай холбоотой сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гаргахад зөрчил гаргасан эсэх талаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж сануулах сахилгын арга хэмжээ авсан. Мөн тус газрын Ёс зүйн дэд хороонд дотоодын хяналт шалгалтын хүрээнд зөрчилтэй тушаал шийдвэр удаа дараа боловсруусан албан хаагчид холбогдуулан гомдол гаргаж шийдүүлсэн.

1.3	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаанд шийдвэрлэх	2025 оны 4-р дүгээр улиралд Абле программаар НДЕГ болон бусад байгууллагаас ирсэн нийт 786 албан бичгээс 751 үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх шатанд 35 албан бичиг байна. Абле программаар 565 өргөдөл хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж хариу хүргүүлсэн болно. Edos программаар нийт 1112 албан бичиг ирснээс 1076 албан бичгийн хариуг хугацаанд шийдвэрлэсэн 36 бичиг хяналтын шатанд байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тоон гарын үсэг ашиглан 599 албан бичиг боловсруулан явуулсан байна. Шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэх процесст саад учирсан тохиолдолд газрын даргад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч, ажиллаж байна. . Мөн Засгийн газрын 11-11 төвд тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой 35 удаагийн гомдол хүсэлт ирсэнийг тухай бүр шийдвэрлэж хариу мэдэгдсэн.
1.4	Удирдлага, ажилтан, албан хаагчдын ажлын хариуцлага, дэг журам, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, албан хаагчдыг идэвхжүүлэх арга хэмжээг санаачлан зохион байгуулах	2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай хамтран албан хаагчдын байгууллагын болон үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор “Байгууллагын соёл ба ажлын цаг ашиглалтыг сайжруулах, албан хаагчдыг идэвхжүүлэх арга хэмжээг санаачлах” сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтын зорилго нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ байгууллагын дотоод уур амьсгал, хамт олны харилцааны соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн юм. Сургалтын үеэр “Байгууллагын соёл ба ажлын цаг ашиглалтыг сайжруулах, албан хаагчдыг идэвхжүүлэх арга хэмжээг санаачлах”, “Харилцааны соёл ба итгэлцлийн орчин”, “Ажилтан бүрийн үүрэг, хариуцлага” зэрэг сэдвээр “Хөгжлийн шийдэл” ТББ-ын бизнесийн зөвлөх ментор Н.Баярчимэг онол, туршлагыг хослуулсан хэлбэрээр мэдээлэл хүргэлээ. Сургалтын үр дүнд албан хаагчид байгууллагын үнэт зүйл, хамт олны уур амьсгал, үйлчилгээний чанар хоорондоо шууд уялдаатай болохыг ойлгож, иргэдэд найрсаг,

		хүртээмжтэй, хариуцлагатай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шинэ санаачилга, хандлагыг төлөвшүүлээ.
1.5	Албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэртэй хуваарилж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, стресс менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар ажилтнуудыг идэвхжүүлэх, ажлын бүтээмжийг нь сайжруулах	Байцаагч, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, Харилцан суралцах, мэдлэг солилцох орчныг бүрдүүлэх, Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, Ажил үүргийн гүйцэтгэлд тулгардаг асуудлыг бодит туршлага, кейс дээр тулгуурлан шийдвэрлэх арга барилд сургах, Багийн ажил, харилцаа, мэдээлэл солилцоог сайжруулж, байгууллагын үйлчилгээний чанар, хариуцлагыг дээшлүүлэх талаар Д.Эрдэнэцэцэг Ч.Сувдмаа С.Оюунцэцэг зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Албан хаагчид харилцан суралцах шинэ арга барил эзэмшиж, ажлын туршлага солилцох чадвар нэмэгдсэн. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд тулгардаг нийтлэг асуудлыг хамтран хэлэлцэж, шийдлийн хувилбаруудыг боловсруулсан. Байцаагчдын харилцааны ур чадвар сайжирч, байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн. Харилцан суралцах арга зүйн сургалт нь Нийгмийн даатгалын газрын байцаагчдын мэргэжлийн ур чадварыг бодитоор нэмэгдүүлж, байгууллагын хяналт шалгалтын чанар, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, соёлд чухал ахиц авчирсан. Сургалтыг цаашид шат ахиулан үргэлжлүүлэн, тогтмол зохион байгуулах нь үр өгөөжтэй албан хаагчид сургалтад хамрагдлаа
ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД:		
		Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилт, нийгмийн даатгалын хуулийн сургалтанд шинээр томилогдсон байцаагч, мэргэжилтэн нарыг мэдлэгийн хүрээг нэмэгдүүлэх, туршлагатай, сахилга, ёс зүйтэй төрийн

2.1	Нийгмийн даатгалын багц хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийг сайтар судлан, албан хаагчдад сургалт хийх	албан хаагч болгох, мэргэшүүлэх, ажлын үр дүнг сайжруулах, үйлчилгээний стандарт чанар, хүртээмжийг дээшлүүлэх, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулж ажиллах ажлын хүрээнд Газрын даргын батлагдаж, жилийн төлөвлөгөөнд тусгасан дотоод сургалт, НДЕГ-аас зохион байгуулж буй цахим сургалт, танхимын сургалт, бие даан эзэмшүүлэх монгол бичгийн сургалтад, Нийгмийн даатгалын улсын байцаагчын шалгалт болон шинэ ажилтан албан хаагчдыг мэргэшүүлэх цахим сургалтанд тус тус хамруулж ажилласан.
2.2	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарийг мөрдөх, Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирлаар жигд ханган биелүүлэх, зарлагын төсвийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулах;	Орлогын төлөвлөгөөний хуваарийг сар бүрээр гарган хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 онд 759,198,986,400 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2025.12.09-ний өдрийн байдлаар 654,442,707,621.36 төгрөг төвлөрүүлж 86% биелэлттэй байна. Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээ тооцоход орлогын төлөвлөгөө 100% биелэнэ гэж тооцож байна.
2.3	“Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” 2025 оны зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд баталсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн болон бусад авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх;	Шимтгэлийн авлагыг барагдуулах талаар дараах арга хэмжээг авч ажилласан. Албан шаардлага хүргүүлсэн – 73 Данс хаасан – 1215 Уулзалт /Уулзалтын тэмдэглэл/ хөтөлсөн ажил олгогч хамрагдана/ - 18 Шимтгэлийн авлага барагдуулах гэрээ байгуулсан – 58 Шүүхэд шилжүүлсэн – 87 ШШГА-нд шилжүүлсэн – 18 Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгаланы хамралтыг нэмэгдүүлэх үүднээс “ИТГЭЛЦЭЛИЙН АЯН”-ыг зохион байгуулсан. Аяны хүрээнд шинээр гэрээ байгуулсан 67, гэрээ сунгасан 8, данс нээсэн 9 ажил олгогч 7,544,430,546.07 шимтгэл төлсөн.

2.4	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийг батлагдсан хуваарийн дагуу зардлын зүйлээр зориулалтын дагуу зарцуулах, өр үүсгэхгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөх, санхүүгийн сахилга батыг баримтлах	НДЕГазрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийг 2,282.6 сая төгрөгөөр баталсан. 2025 оны 11 сард тодотгон 236.9 сая төгрөгөөр бууруулан 2,045.7 сая төгрөгөөр баталсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд зардлын зүйл анги, зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг баримтлан өр авлага үүсгэхгүйгээр ажилласан.
2.5	Нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тухай бүр хууль зүйн хүчин төгөлдөр баримтыг үндэслэн бүртгэх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зөрчил илэрсэн бол тухай бүр дээд шатны удирдлагад мэдээлэх, таслан зогсоох, давтан гаргахгүй байх;	Нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль журмын дагуу бүртгэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангаас зардал гаргах, бүртгэл хөтлөхдөө анхан шатны баримтын бүрдлийн ханган, шат дараалсан хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, хяналт шалгалтын байгууллагын шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр анхааран ажиллаж байна.
2.6	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн санхүүгийн хэрэгсэлд оруулах ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулах;	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төв санд цаг тухай бүрт нь төвлөрүүлэн, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах хууль, журмыг хэрэгжилтийг ханган ажиллаа. 2025 оны турш 861,0 тэрбум төгрөгийг төв санд төвлөрүүлэн ажилласан.
2.7	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ SICOS системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг бүрэн хийж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Ай ти зоне ХХК-аас “Ажил хүлээлцсэн акт”-аар баталгаажуулан хүлээн авах,	

2.8	Цахим архив буюу даатгуулагчдад олгож байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг SICOS системийн цахим архивд бүртгэн оруулж 1995-2005 оны өгөгдлийн сан үүсгэх	Газарт архивлагдаж байгаа шимтгэл төлөлтийн мэдээллийг үе шаттайгаар цахим архивт шилжүүлэн өгөгдлийн санг бүрдүүлэн ажиллаж байна.
2.9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Shilendans.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь мэдээлэх, мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэх;	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Shilendans.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь байршуулж ажилласан. Дээрх ажлын хүрээнд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сангийн болон үйл ажиллагааны орлого зарлага, төсөв төлөвлөгөө, тушаал шийдвэр болон бусад мэдээллийг бүрэн байршуулсан. НДЕГ-аар Дотоод аудит, мониторингийн газраас хийсэн мониторингоор илэрсэн мэдээлэл байршуулалттай холбоотой зөрлийг давтан гаргахгүй байхад анхааран ажиллаж байна.
2.10	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Shilendans.gov.mn цахим хуудас болон байгууллагын /ndaatgal.mn/ вэб хуудаст хуулийн дагуу байршуулвал зохих мэдээллийг бодитой, эх сурвалжтай, хугацаанд нь 100 хувь байршуулах;	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2023 оны 05 дугаар сарын 26 ний 01/1132 тоот албан бичгийн дагуу хэлтсийн Цахим хуудсыг шинэчилж сайжруулан идэвхижүүлэх ажлыг тогтмол хийж ажиллаж байна. Тус албан бичгийн дагуу дараах 5 бүлэгт мэдээлэл шинэчлэлт хийж байна. Үүнд: 1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулагдтын тадаарх мэдээллийн тл тод, нээлттэй байдал 2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 3. Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга иол тод, нээлттэй байдал 5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал

		Дээрх 5 бүлгийн 48 мэдээллийг байршуулахаас 30 мэдээллийг байршуулан ажилласан байна. www.chingeltei.ndaatgal.mn сайтаа www.shilendans.gov.mn холбон 27 төрлийн мэдээллийг улиралдаа шинэчлэн ил тод болгон ажиллаж байна. Веб хуудсаар Төрийн албан хаагчийг авлига, хээл хахууль авах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлан пост оруулан ажиллаж байна.
Гурав. Дотоод хяналтыг сайжруулах, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах хүрээнд:		
3.1	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, шимтгэл ногдуулалт, төлөлтийн тайлан тооцооны үндэслэлд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу аж ахуйн нэгж байгууллагуудыг бүрэн хамруулах, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн, зохион байгуулсан хяналт шалгалтын ажлын үр дүнг тооцож ажиллах	Газрын даргын 2025 оны 1-р сарын 13-ны өдрийн баталсан 02 тоот удирдамжийн дагуу ажил олгогчдод Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, хуримтлагдсан өр авлагыг бууруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр ажил олгогчийн жагсаалт гарган батлуулж хуваарийн дагуу байцаагчид хяналт шалгалт хийсэн. Тайлант хугацаанд нийт 202 ажил олгогчийг шалгаж. 1,2 тэрбум төгрөгийн цалингийн санд 279,6 сая төгрөгийн акт тогтоож 139,8 сая төгрөгийн алданги тогтоож 100% төлүүлэн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна 2025 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 5592 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/199 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.
3.2	Тэтгэврийн тогтоолт, олголтод тавих дотоодын хяналтыг сайжруулж тэтгэврийн олголтын тооцоог тэтгэвэр авагч бүрээр сар бүр тогтмол хийж илүү, дутуу олгогдсон олголтын зөрчил, дутагдлыг тухайн сард багтаан барагдуулж байх	2025 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу нийт даатгалын сангаас 1-24 хороонд шинээр 1344 иргэний хуулийн

		хугацаанд хүлээн авч “SICOS” программд мэдээллийг бүрэн оруулж, хүсэлтийг үүсгэн, нийгмийн даатгалын мэдээллийн бааз, иргэний бүртгэлийн мэдээллийн баазтай тулган шалгаж, тогтоож, хянан баталгаажуулж шийдвэрлэж ажилласан. ННДГ-ын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр баталсан 2 тоот удирдамжийн дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн хэрэгжилтийг шалгах хяналт шалгалтаар хуурамч бичиг баримтаар тэтгэвэр тогтоосон, үндэслэлгүй илүү олгосон зөрчилд тавигдсан улсын байцаагчийн актаар тогтоогдсон 38 иргэний 656,07 сая төрөгний актнаас 2024 оны эхний үлдэгдэл 37 иргэний 279,8 сая төгрөнөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 17 иргэний 56,3 сая төгрөг барагдаж үлдэгдэл 21 иргэний 223,5 сая төгрөгийн үлдэгдэлдтэй байна. Үүнээс зөрчилтэй 2 тэтгэвэр авагч нас барж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тусгай зохицуулалтын тэтгэврийг тогтоож, тэтгэврээс сар бүр иргэний өргөдлийн дагуу 100 хувь суутгалыг хийж, зөрчлийн барагдуулалтын ажлыг үргэлжлүүлж байна. 9 иргэний тэтгэврийн суутгалыг 100 хувь суутгаж, 3 иргэний тэтгэврээс 80 хувь суутгаж, 6 иргэний тэтгэврээс 50 хувийн суутгалыг сар бүр хийж, санхүүд шилжүүлж байна.
3.3	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийг бүрэн барагдуулэх	Газрын даргын 2025 оны 1-р сарын 13-ны өдрийн баталсан 02 тоот удирдамжийн дагуу ажил олгогчдод Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, хуримтлагдсан өр авлагыг бууруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр ажил олгогчийн жагсаалт гарган батлуулж хуваарийн дагуу байцаагчид хяналт шалгалт хийсэн. Тайлант хугацаанд нийт 202 ажил олгогчийг шалгаж. Анхан шатны нотлох баримтыг үндэслэн 1,2 тэрбум төгрөгийн цалингийн санд 279,6 сая төгрөгийн акт тогтоож 139,8 сая төгрөгийн алданги тогтоож 100% төлүүлэн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна 2025 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 5592 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/199 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу

		хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.
3.4	Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг цахимаар болон баримт бичигт үндэслэн шийдвэрлэхдээ дотоодын хяналтыг сайжруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, болзошгүй алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах	Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг цахимаар баримт бичигт үндэслэн шийдвэрлэхдээ дотоод хяналт, эмнэлгийн амбулоторийн картны шинжилгээ, оношилгооны бүрдэлт, эмчийн үзлэг, сэргээн засах, эмчлэн эрүүлжүүлэх, хяналтуудыг сайжруулах, магадлалтай холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Чингэлтэй дүүргийн 19 хорооны 16 өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нар, харьяалах эрүүл мэндийн хувийн хэвшлийн болон төрийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарах тухай сургалтыг танхимаар зохион байгууллаа. Сургалтанд Чингэлтэй нийгмийн даатгалын сургалтын албаны мэргэжилтэн Т.Баатархүү авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай сургалт хийсэн. 2025 оны 05 -р сарын 20-нд цахимаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Авлигатай тэмцэх” сургалт явуулахад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга болон бүх гишүүд хамрагдлаа. “Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам”-наас хийсэн шторконд магадлагч эмч оролцож Нийгмийн даатгалын ерөнхий хууль,авлигын эсрэг, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, гишүүд нь авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй байх мэдээлэлийг олон нийтэд өгөх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдөр албан ёсны фэйсбүүк хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
3.5	Эрүүл мэндийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулах арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг	2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалттай хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээний үр дүнг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтанд

	зохион байгуулж хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог бууруулахад анхаарч ажиллах;	хүргэж буй зонхилох 5 өвчний урьдчилан сэргийлэлт хийх, ажлын хүрээнд эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт, даатгуулагч хүний эрүүл мэндтэй холбоотой амбулаторийн картын хавтаслалт, эмх цэгц, шинжилгээ оношилгооны дүгнэлт, хяналт, баталгаажилтыг сайжруулахаар Чингэлтэй Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөс Чингэлтэй дүүргийн 1-24 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн дунд 2 сарын аяныг зохион байгуулж, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх, эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, магадлалын харилцаанд оролцогч талуудыг болзошгүй алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнг нэмэгдүүлэхээр ажилласнаар аяны үр дүнд эрүүл мэндийн бүртгэл маягтын дагуу хяналт сайжирч, картны эмх цэгц болон даатгуулагч иргэд эмчийнхээ заавар зөвлөмжийг даган сэргээн засах эмчилгээг үр дүнтэй хийлгэж хамралт нэмэгдсэнээр хөдөлмөрийн чадвар алдалтын тоо 2024 онд 3727/ 2,8%-тай байсан бол 2025 онд 3617/ 2,6%-тай болж буурсан үзүүлэлттэй байна.
3.6	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, даатгуулагчаас хууль тогтоомжид заагаагүй баримт бичиг, нийгмийн даатгалын болон бусад төрийн байгууллагад байгаа мэдээллийг шаардахгүй байх	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг олгохдоо мэдээллийн баазад тулгуурлан санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэн, нэмэлт баримт бичиг шаардахгүйгээр ажиллаж байна.
3.7	Нийгмийн даатгалын байгууллагын ажлын байр болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, байцаагч ажилтнуудын иргэд даатгуулагчдад үзүүлэх үйлчилгээний соёл, харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэ ажил санаачлан зохион байгуулж, үр дүнг тайлагнах;	2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай хамтран албан хаагчдын байгууллагын болон үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор “Байгууллагын соёл ба үйлчилгээний чанар” сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтын зорилго нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ байгууллагын дотоод уур амьсгал, хамт олны харилцааны соёлыг төлөвшүүлэхэд

		чиглэгдсэн юм. Сургалтын үеэр “Байгууллагын соёл ба иргэдэд үзүүлэх үйлчилгээний хандлага”, “Харилцааны соёл ба итгэлцлийн орчин”, “Ажилтан бүрийн үүрэг, хариуцлага” зэрэг сэдвээр “Хөгжлийн шийдэл” ТББ-ын бизнесийн зөвлөх ментор Н.Баярчимэг онол, туршлагыг хослуулсан хэлбэрээр мэдээлэл хүргэлээ. Сургалтын үр дүнд албан хаагчид байгууллагын үнэт зүйл, хамт олны уур амьсгал, үйлчилгээний чанар хоорондоо шууд уялдаатай болохыг ойлгож, иргэдэд найрсаг, хүртээмжтэй, хариуцлагатай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шинэ санаачилга, хандлагыг төлөвшүүллээ.
3.8	Байгууллагын пэйж болон веб хуудсыг тогтмол хөтлөн, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр оруулах, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйжид тавьж байгаа мэдээ, мэдээллийг шэйрлэж, олон нийтэд түгээх, ташаа мэдээлэлд тухайн өдөрт нь багтаан тайлбар, мэдээлэл өгч хэвших;	ГБХНХЯам болон холбогдох дээд шатны байгууллага, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг тухай бүр олон нийтэд цаг алдалгүй шуурхай түгээж ажиллаж байна. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлт, цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор батлагдсан хуваарийн дагуу сард 1-2 шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. 2025 оны 4 улирлын байдлаар нийт 13 удаа шууд Live хийж, 27500 гаруй иргэд даатгуулагчид үзсэн хандалттай байна. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, эрх зүйн орчныг иргэд, олон нийтэд таниулах зорилгоор ажлын төлөвлөгөө гарган, рийл, постер бэлтгэн олон нийтийн сүлжээгээр, байгууллагын цахим хуудсаар хүргэж ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.ДАВААДОРЖ

АЛБАН ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ БИЧСЭН:

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ГЭРЭЛТУНГАЛАГ